



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ПХБ-ИЙН ТӨСЛИЙН ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛАХ КОНТЕЙНЕРИЙГ РП-22-
ЫН ХАШААНД БАЙРЛУУЛАХ АГУУЛАХЫГ MNS 64582014 СТАНДАРТЫН ДАГУУ
ТОХИЖУУЛАХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ**

Тендерийн нэр: ПХБ-ийн төслийн химийн хортой бодис хадгалах контейнерийг РП-22-
ын хашаанд байрлуулах агуулахыг MNS 64582014 стандартын дагуу
тохижуулах

Тендерийн дугаар: ЦДҮС/202001043

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “ПХБ-ийн төслийн химийн хортой бодис хадгалах контейнерийг РП-22-ын хашаанд байрлуулах агуулахыг MNS 64582014 стандартын дагуу тохижуулах” гүйцэтгэгчийн тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 30,000 /гучин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстай.

Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны 09:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДУС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2020 оны 04 дүгээр сарын 10-ны 09:10 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн
өргөн чөлөө-45, “ЦДУС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар, 309
тоот**
Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс
Утас: 99039494

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг запруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг запруулна.
- 6.2. Захиалагчийн запруулсан тендерийн дүнг тендерт оролцгийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч запруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- | | |
|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-НЫХОЛБОГОДХОЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн нэг жилийн (2019 он) санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн 2 жилийн (2018, 2019 он) туршилагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар гэрээ гүйцэтгэсэн акт дүгнэлийн хамт ба 2-оос дээш байгууллагын үзлэг шинжилгээ хийсэн байх/; - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/ - Компанийн дэлгэрэнгүй танилцуулга - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт - Шүүхийн төрөлжсөн архивын лавлагагаа ирүүлнэ. - Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар захирагааны хэргийн анхан шатны шуухийн тодорхойлолт ирүүлнэ. - Нийгмийн даатгалын хэлтсийн өр төлбөргүй талаар тодорхойлолт - Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. /Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өрийг шалгахад өртэй байвал уг тендерээс татгалзах үндэслэл болно./ - Ажил гүйцэтгэх хуваарь - Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл: /баталгаажуулах/ 2.1.1 /Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт/ -тусгай зөвшөөрлийн шаардлагын дагуу үндсэн тооног төхөөрөмж машин механизмтай байна. - Техникийн тодорхойлолтод заасан ажлын даалгавар, ажлын тоо хэмжээ, техникийн шаардлагын дагуу төсөөв боловсруулж ирүүлнэ. Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхийн төсөөвчнөөр баталгаажуулсан байна. - Захиалагчын албаны буюу техник хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, нормчлолын сангийн зардлыг төсөөв зохиох зааврын дагуу, татвар хураамжыг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ. - Бараа, бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга, зураг, - Чанарын стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн санал болгоно <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ</p> <p>Огноо: Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр цахим системээр илгээх</p> <p>Цаг: 09 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДУС” ТӨХК-ийн төө байр.</p>

	Огноо: Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны Цаг: 09 цаг 10 минут.
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: “ПХБ-ийн төслийн химийн хортой бодис хадгалах контейнерийг РП-22-ын хашаанд байрлуулах агуулахыг MNS 64582014 стандартын дагуу тохижуулах” ЦДҮС/202001043

Дөрөв. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

ПХБ-н төслийн химийн хортой бодис хадгалах чингэлгийг РП-22 хашаанд
байрлуулж, хашааны хөрсөнд бодис нэвчихээс хамгаалсан суурийн ажил гүйцэтгэх
ба MNS 6458: 2014 стандартын дагуу тохижуулж сайжруулах ажлын техникийн
шаардлага болон үзүүлэлт

Зорилго.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-н “РП-22” аж ахуйн хашаанд шинээр байгуулах агуулахын байгууламж нь шинэ химийн урвалж бодис, дагалдах материал болон хаягдал урвалж бодисыг түр хадгалах зорилготой. Байгууламжид 3 ширхэг чингэлгийг суурилуулаха ба 1-р чингэлэг нь зөвхөн шинэ материал хадгалах, 2 болон 3-р чингэлэг нь хаягдал материал түр хадгална.

Ерөнхий шаардлага.


Агуулах байгууламж нь дараахь шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- Байгууламжийн нийт талбайн хэмжээ 224м² байх ба хашааны хэмжээ нь 14м*16м байна.
- Байгууламжийн суурь нь хотгор, гудгэр, нух, хэвгий хазайлтгүй тэгш байх ба хөдөлгөөнгүй, халтирааргүй гадаргуутай, химийн бодист тэсвэртэй материал (эпокси г.м)-аар хийгдсэн байна. Суурийн хэмжээ 12м*14м байна. Суурийн зузаан 25 см байх ба хагаралт цууралтаас сэргийлж арматур төмөр краказ зангидааж хүчитгэнэ.
- Суурь нь ус нэвчдэггүй материалаар хийгдсэн хийгдсэн байх ба асфальт байж болохгүй.
- Байгууламжийн суурь нь асгарч алдагдах бодис гадагш алдагдахаар нух сув, зайд завсаргүй байна.
- Байгууламжийн хашаанд доторх хүчитгэсэн сууринаас бусад хэсгийг хайрга дайргаар дүүргэсэн байна.
- Байгууламж нь 1,8м-ээс багагүй өндөртэй хамгаалах хашаатай байна.
- Хашаа нь цоожтой, шөнийн цагаар гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй байна.
- Хашааны дээд ирмэгээр хамгаалах өргөст утас бэхэлсэн байна.
- Хашааны үндсэн хаалга нь 3 метр байна. Туслах (аваарийн) гарцны хаалганы өргөн 1,2 метр байна.
- Байгууламжийн гадна талд цугларах аюулгүйн цэгийг тогтоон, түүнийг тэмдэгжүүлсэн байна.
- Цахилгааны ерөнхий самбар болон газардлагуудыг хийнэ.
- Байгууламжийн гэрэлтүүлгийг тээврийн хэрэгслийн явах түвшнээс дээш байрлуулна.

- Цахилгааны гэрэлтүүлэг нь хамгаалалтын бүрхүүлтэй байх ба цахилгаан монтажны утас нь далд суурилагдсан эсвэл ил байрлуулах тохиолдолд механик гэмтлээс хамгаалсан хамгаалалттай байна.
- Зэргэлдээх барилга байгууламж болон тээврийн хэрэгслийн замаас бодис хадгалах задгай агуулахыг 6м-ээс бага зайд байрлуулж болохгүй.
- Бараа материал хадгалах агуулах нь дотроо эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хайрцагтай байна.
- Агуулахад хадгалагдаж буй бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан гал унтраах хэрэгслийг "Гал түймрээс хамгаалах, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага MNS5566:2005"-т заасны дагуу байрлуулна.
- Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд ил харгдахуйцаар байрлуулсан байна.
- Химиин хорт болон аюултай бодисын агуулахад "Химиин хорт болон аюултай бодис шошго, анхааруулах тэмдэг. MNS5029:2011"-д заасан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээг мөрдөнө.
- А хавсралтаар заасан хориглох тэмдгийг нүдэнд ил харгдахуйцаар байрлуулна.
- В хавсралтаар заасан нэг бүрийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх, шаардлагатай газарт тэмдэглэгээг байрлуулна.
- С хавсралтаар заасан аврах зам, гарц, цугларах цэг болон анхны тусламжийн хайрцаг, хэрэгслийн байршил, чиглэлийн заасан тэмдэглэгээг нүдэнд ил харгдахуйцаар байрлуулна.



РП-22-н хашаанд байрлах ПХБ-н төслийн материал агуулах байгууламжийн ерөнхий план



MNS 6458 : 2014

А Хавсралт
(норматив)
Хориглох тэмдэг



Нэвтрэхийг хориглоно



Галын аюултай



Ачигч тэрэг ашиглахыг
хориглоно



Үндны ус авахыг
хориглоно



Нэвтрэх зөвшөөрөлгүй хүн
орохыг хориглоно



Тамхи татахыг хориглоно



Гал унтраахад ус
хэрэглэхийг хориглоно

MNS 6456 : 2014

В хавсралт
(норматив)

Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл



Чижний хамгаалалт



Нүдний хамгаалалт



Нүүрний баг



Нэвтрэх зөвшөөрөлгүй хүн орохыг хориглоно



Хамгаалалтын хувцас



Амьсгал хамгаалах баг



Хамгаалалтын бэзлий



Хамгаалалтын малгай



Хамгаалалтын гутал

MNS 6458 : 2014

С Хөвсрэлт
(норматив)

Аврах зам, гарц, цугларах цэг болон анхны тусламжийн хайрцаг,
чиглэл заасан тэмдэглэгээ



Материалын тооцоо

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нийт орц
1	Резинэн шал эпокси	кг	15.895
2	Том хаалганы самбар	кг	204.7
3	Төмөр утас	кг	0.56
4	Төмөр утас ф 5 мм	кг	3.927
5	Хашааны төмөр утсан тор	м2	84
6	Хашааны шон	ш	16.464
7	Хадаас /70-110мм/	кг	3.2487
8	Хайрга 10-20мм	м3	25
9	Цоож	ш	2
10	Цемент шохойн зуурмаг м-50	м3	0.0143
11	Электрод э-42	кг	4.14
12	Эмнэлэгийн анхан шатны хайрцаг	ш	2
13	Банзан бамбай 25 мм	м2	12.138
14	Бэхэлгээ төмөр	кг	533.12
15	Бетон зуурмаг м-200	м3	36.2355
16	Автоматтай самбар пр 9111	ш	1
17	Арматур ф10	тн	1.1817
18	Газардуулгын шин	м	30
19	Галын булан	ком	2
20	Гэрэлтүүлэгч прожектор /300W-аас багагүй/	ш	2
21	Гэрэлтүүлгийн шон 3м	ш	2
22	Захалсан банз, IV зэрэг, 2м-ээс дээш урт, 44мм зузаан	м3	0.1367
23	Жижиг хаалганы самбар	кг	54.8
24	Кабель 2x4 мм2	м	50
25	Плакат тэмдэг	ш	22
26	Өргөст торон утас	м	56

Ажлын даалгавар

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нийт орц
1	Бетон шахах шахуургаар Баганын 25м3 -ээс дээш эзлэхүүнтэй төмөр бетон суурь цутгах	м3	35.7
2	Хөрсийг хайргаар нягтруулж дэвсгэр үе хийх	м3	20
3	Бетон гадаргууг резинээр шаллах	м2	144.5
4	1.8 м өндөртэй хаявчгүй төмөр бетон шонтой төмөр хашаа	м	56
5	Төмөр хашааны том хаалга	ш	1
6	Төмөр хашааны шонгүй жижиг хаалга	ш	1
7	Хаалганд цоож суулгах	ш	2
8	Гэрэлтүүлгийн самбар угсрах жин 28кг хүртэл	ш	1
9	Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсрах	ш	2

10	220В-ийн кабелийн шуудууг гараар ухах	м3	7
11	Шуудуу хүнхээл нүхийг эргүүлж булах	м3	6.65
12	1кг хүртэл жинтэй кабелийг шуудуунд сунгах	м	50
13	Газардуулгын шинийг шуудуунд угсрал	м	30

Тав. ЖИШИГ МАЯГТ
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|-------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
- В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**
- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**
- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон

ажлыг хүлээж авна.

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гарана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “ПХБ-ийн төслийн химийн хортой бодис хадгалах контейнерийг РП-22-ын хашаанд байрлуулах, MNS 64582014 стандартын дагуу тохижуулах” ЦДУС/202001043
ГЕН 2.1	Ажил нь “ПХБ-ийн төслийн химийн хортой бодис хадгалах контейнерийг РП-22-ын хашаанд байрлуулах, MNS 64582014 стандартын дагуу тохижуулах” Ажлын талбай нь : УБ хот, СХД-ийн 22-р хороо ЦДУС ТӨХК –ийн РП-22 хашаа
ГЕН 3.1	Төслийн менежер нь :
ГЕН 4.1	<u>Зөвшөөрөл авч ажил эхлэсэн өдрөөр тооцогдоно.</u> Ажил эхлэх өдөр 2020 оны дугаар сарын -ны өдөр Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацаа. Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 14 хоногийн хугацаанд үзлэг шинжилгээ хийж дуусах
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа [365] хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05% байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5% байна.
ГЕН 16.1	Ажлыг шалгаж хүлээн авсан акт ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн төлбөрийн 95%-ийг төлнө. Эцсийн төлбөр болох 5 хувийг баталгаат засварын хугацаа дуусахад төлөх ба банкны батлан даалтыг захиалагчид гаргаж өгснөөр уг төлбөрийг урьдчилан авч болно. <u>Урьдчилгаа төлбөр:</u> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн дагуу Урьдчилгаа төлбөр төлж болно. Урьдчилгаа төлбөрийг маягтын дагуу харилцагч банкны баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан дүнгээр олгоно. Харилцагч талуудын хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээ, мөнгөн гүйлгээг тухайн жилийн 2-р дугаар улирал болон жилийн эцсийн байдлаар тодруулж хоорондын тооцооны үлдэгдлийг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу баталгаажуулна. Тооцооны үлдэгдлийг талуудын хооронд үүссэн данс тус бүрээр баталгаажуулж хөтөлнө.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 100%-иар тооцно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, ____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.8. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]